Монгол Улс
Барилгын инженер-хайгуулын
“Энх-Өрнөлт” ХХК.

Баянхонгор аймгаас Архангай чиглэлийн авто замын инженерийн нарийвчилсэн зураг төсөлд зориулсан инженер-геологийн судалгааны дүгнэлт

/эхний 30 км, Баянхонгор-Баян-Овоо сум/

Улаанбаатар хот.
2025 он

Монгол Улс
Барилгын инженер-хайгуулын
“Энх-Өрнөлт” ХХК.

Архив № 25-039 **ЗТП – 518/24**

MONGOLIA CONSULTING ENGINEER TUNGALAG Gendendorj 03-436

11-9
2025 8 25

Баянхонгор аймгаас Архангай чиглэлийн авто замын инженерийн нарийвчилсэн зураг төсөлд зориулсан инженер-геологийн судалгааны дүгнэлт

/эхний 30 км, Баянхонгор-Баян-Овоо сум/

/ Ажлын зургийн шатанд зориулав /

Батлав: МОНГОЛ УЛС ЭНХ-ӨРНӨЛТ ХХК 2085704 УБМ00514 УЛААНБААТАР ХОТ

Захирал:……/Б.Мөнхбадрах/

МОНГОЛ УЛС 19-3472 АТХ8354 Баянцагааны САРАН МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР ЗТ-ИГГС 2022-2025

Хянасан: ……/Б.Саран/
/Мэргэшсэн инженер/

МОНГОЛ УЛС 16-2080 АТХ8352 Ёсчинбүүгийн АРИУНАА МЭРГЭШСЭН ИНЖЕНЕР ЗТ-ИГГС ХУГАЦААГҮЙ

Боловсруулсан: ……/Ё.Ариунаа/
/Мэргэшсэн инженер/

Улаанбаатар хот.

2025 он

ГАРЧИГ

I. ОРШИЛ 3

1.1 Судалгаа хийсэн үндэслэл 3
1.2 Инженер-геологийн судалгааны ажлын хэмжээ, аргачлал 3

II. СУДАЛГААНЫ ТАЛБАЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ 6

2.1 Байршил 6
2.2 Маршрутын бичиглэл 6
2.3 Геоморфологийн хэв шинж, Физик-геологийн үзэгдэл үйл явц 9
2.4 Геологийн тогтоц 10
2.5 Геокриологийн нөхцөл 14
2.6 Гидрогеологийн нөхцөл 14
2.7 Цаг уур 14

III. СУДАЛГААНЫ ТАЛБАЙН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ, УЛ ХӨРСНИЙ ФИЗИК-МЕХАНИК ШИНЖ ЧАНАР 18

3.1 Талбайн инженер-геологийн нөхцөл 18
3.2 Ул хөрсний физик-механик шинж чанар 18

IV. МАТЕРИАЛЫН ХАЙГУУЛ БА ТҮҮНИЙ ШИНЖ ЧАНАР 25

V. ТОВЧ ДҮГНЭЛТ 28

VI. ЦООНОГИЙН КАТОЛОГИ 30

VII. ЦООНОГИЙН БИЧИГЛЭЛ 31

Хавсралт материалууд

1.	Лабораторийн шинжилгээний үр дүнгийн хүснэгт	Хавсралт хүснэгт№1-7
2.		
3.	Материалын шинжилгээ	Хавсралт хүснэгт№1 -2
4.	Малталтын байршлын зураг	Хавсралт зураг№1-4 Масштаб 1:20 000
5.	Инженер-геологийн зүсэлт, таних тэмдэг	Хавсралт зураг№5-25

Ашигласан материал

1. Барилгын инженер-геологийн ажил БНбД 11-03-01
2. "Монгол орны нутаг дэвсгэрт шугаман байгууламжийн инженер-геологийн судалгаа хийх заавар БД 11-107-10
3. Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл АЗУАГН-01-01-2004
4. Барилгад хэргэлэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт БНбД. 23-01-09.
5. Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрмийн тайлбар дүрэм БНбД 50-103-21
6. Инженер-геологийн судалгааны ажлын тайлан, дүгнэлт бичих дүрэм. БД-11-107-11. Улаанбаатар 2011 он.
7. Инструкция по применению электроразведочных методов в инженерных изысканиях для стройтельства
8. Газар хөдлөлийн бүс нутагт барилга байгууламж төлөвлөх БНбД 22-01-21 Улаанбаатар хот 2021 он.

I. ОРШИЛ

1.1 . Судалгаа хийсэн үндэслэл:

"Аварга зам" ХХК болон Барилгын инженер-геологийн "Энх-Өрнөлт" ХХК–ний хооронд байгуулсан инженер-геологийн судалгааны ажил гүйцэтгэх гэрээ, техникийн даалгаврын дагуу Баянхонгор аймгаас Архангай чиглэлийн автозамын инженерийн нарийвчилсан зураг */Эхний 30 км, Баянхонгор аймгийн Баян-Овоо сум/* төсөлд зориулсан трассын дагуух инженер-геологийн судалгааг Барилгын инженер-геологийн "Энх-Өрнөлт" ХХК–аас 2025 оны 8-р сарын 09-ны өдрөөс 8-р сарын 22-ны өдөр хүртэл хээрийн судалгаа, лабораторийн шинжилгээ, суурин боловсруулалтын гэсэн 3 үе шаттайгаар хийж гүйцэтгэж байна.

1.2. Инженер-геологийн судалгааны ажлын хэмжээ, аргачлал:

- Судлагдсан авто замын трассын эхний хэсэг нь нийт 30 км урт үргэлжилнэ. Хээрийн судалгааны ажлыг явуулахдаа "Монгол орны нутаг дэвсгэрт шугаман байгууламжийн инженер-геологийн судалгаа хийх заавар БД 11-107-10, Барилгын инженер-геологийн судалгааны ажил гүйцэтгэх БНбД 11-03-01-ийн дагуу өрмийн УГБ-1ВС төхөөрөмжөөр, дээжлэлттэйгээр баганат өрөмдлөгийн аргаар өрөмдөв. Судалгааны явцад талбайн хөрсний тархалт, зүй тогтлыг тодорхойлох зорилгоор трассын дагууд 500-1500 метрийн зайтай 2,5-4,2 метрийн гүнтэй 29 цооног өрөмдсөн.
- Өрөмдсөн цооногуудаас хөрсний 40 ш дээж авч лабораторийн туршилт шинжилгээ хийсэн бөгөөд шинжилгээний үр дүнг ашиглан хөрсний төрөл зүйлийг тогтоож нэгтгэн боловсруулав. Замын трассын дагуух материалын карьеруудыг тогтоох зорилгоор дайрганы 1, элсний 1 сорьцлолт хийв.
- Хээрийн судалгаа, туршилтын ба лабораторийн шинжилгээний үр дүнг нэгтгэн боловсруулж энэхүү дүгнэлтийг бичсэн бөгөөд суурин боловсруулалтын ажилд захиалагчаас ирүүлсэн 1:20 000 масштабтай байршлын зураг, Хэвтээ 1:5000, Босоо 1:100 масштабтай дагуугийн зүсэлтийг ашиглан малталтуудыг байрлуулж амсрын өндөржилтийг тогтоож өгөв.
- Судалгааны талбайд өрөмдсөн цооногуудын координатуудыг тогтоосон.
- Суурин боловсруулалтын ажлыг тухайн районд өмнө нь хийж байсан геологийн болон инженер-геологийн судалгааны материалуудыг судлаж, талбайн хэмжээнд хийсэн инженер-геологийн судалгааны материалуудыг эмхэтгэн тайланг 2 үе шаттайгаар боловсруулав. Үүнд:

Судалгааны бүх үе шатны ажлыг БНбД.11-03-01-ын 2-р бүлгийн үндсэн шаардлагын хүрээнд хийж гүйцэтгэж байгаа бөгөөд судалгааг дараах аргачлалаар явуулав. Үүнд:

1. Хээрийн судалгааны арга /Өрөмдлөгийн ажил/
2. Лабораторийн шинжилгээний арга
3. Суурин боловсруулалтын аргаар хийж гүйцэтгэв.

1.1 Хээрийн судалгааны аргад өрөмдлөгийн ажил, ул хөрсний дээжлэлтийн ажлууд орно.

Өрөмдлөгийн ажил:

Инженер-геологийн хээрийн судалгааны өрөмдлөгийн ажлыг 2025-оны 8-дугаар сарын 09-11-ний өдрүүдэд инженер-геологич Ц.Тамирын удирдлагаар УГБ-50М маркийн өрмийн төхөөрөмжөөр баганат өрөмдлөгийн аргаар өрмийн мастер Y.Давгасүмбэрэл, өрмийн ажилчин Э.Баянмөнх нарын бүрэлдэхүүнтэй бригад хийж гүйцэтгэсэн.

/Фото. ПК0+020 трассын эхлэл/

/Фото. ПК30+020 трассын төгсгөл/

Лабораторийн ажил:

Ул хөрсний физик-механик шинж чанарыг тодорхойлох зорилгоор 40 ш дээж авч лабораторийн шинжилгээг "Энх-Өрнөлт" ХХК-ний лабораторид тус лабораторийн хөрс судлаач Б.Саран хийв. Талбайд илэрсэн хөрсний физик-механик шинж чанарын үзүүлэлтүүдийг MNS 3263:2014-ээр ангилж, физик шинж чанарыг MNS 2143-2000-ын стандартуудын дагуу лабораторийн нөхцөлд хийж гүйцэтгэв.

Мөн материалын карьерт зориулж дайрганы 1, элсний 1 дээж авч "Намнан индастри" ХХК-ийн Барилгын материалын сорилтын итгэмжлэгдсэн лабораторит ахлах шинжээч инженер М.Ганпүрэв, материалын шинжээч инженер Р.Даваажаргал нар ASTM, MNS-AASHTO стандартын дагуу хийж холбогдох үзүүлэлтүүдийг тодорхойлов. */Хавсралт хүснэгт үз/* Дайрганы ширхэглэлийн бүрэлдэхүүнийг MNS AASHTO T27:2003 стандартын дагуу, далан суурийн материалыг MNS ASTMD1883-2002 стандартуудын дагуу тодорхойлж тайланд хавсаргасан болно. */Хавсралт хүснэгт үз/*

/Лабораторийн нөхцөлд хувийн жинг тодорхойлж байгаа нь/

/Лабораторийн нөхцөлд уян налархайн туршилт хийж байгаа нь/



/Фото. Ширхэгийн бүрэлдэхүүн болон шаварлаг хэсгийн фракцын туршилт хэмжилт хийж байгаа нь/

<u>Суурин боловсруулалтын ажил:</u>

Суурин боловсруулалтын ажилд хээрийн тэмдэглэл болон лабораторийн шинжилгээний үр дүнг нэгтгэн боловсруулсаны үндсэн дээрээс дэвсгэр зурагт цооногуудыг байрлуулан тэдгээрийн зүсэлтийг зохиолоо.

Хээрийн өрөмдлөг судалгааны материал, лабораторийн шинжилгээний үр дүн, өмнөх судалгааны материал зэргийг харьцуулан боловсруулалт хийж судалгааны дүгнэлтийг мэргэшсэн инженер Ё.Ариунаа бичив.

II. СУДАЛГААНЫ ТАЛБАЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 Байршил:

Төлөвлөж байгаа авто замын трассын эхлэл Баянхонгор аймгийн төвөөс эхлэн баруун хойш Баян-Овоо сумын нутаг дэвсгэр хүртэл 30 км урт үргэлжилнэ. */Байршлын ерөнхий схем үз/*

/Зураг-1. Судалгааны трассын ерөнхий чиглэл/

2.2. Маршрутын бичиглэл:

Баянхонгор-Баян-Овоо хүртэлх 30 км автозамын трассын эхлэл нь Баянхонгор хотын баруун урд талын хатуу хучилттай авто зам болох ПК+0+000-ээс эхэлнэ.

/Фото. Трассын эхлэл. Хатуу хучиллтай автозамаас 20 м зайд, ПК0+020/

ПК0+000-ПК1+300 хүртэл тэгш талын рельеф зонхилох бөгөөд энд 0,2 метрийн зузаантай ургамлын үндэс бүхий бор хүрэн өнгийн өнгөн хөрсөөр хучигдсан элсэн чигжээстэй хайрган ул хөрс 2,0 метр үргэлжлээд дундаа хайрга агуулсан элсэнцэрийн мишил үеийг агуулсан элсэнцэр чигжээстэй хайрган ул хөрс тархсан байна.

/Фото. ПК1+300 Тэгш талын рельеф зонхилно/

ПК1+500-гаас трасс нь намхан уулсын бэл хормойгоор үргэлжлэх ба энэ хэсэгт өнгөн хөрсний зузаан 0,3 м орчим, дээрээ цайвар шаргал өнгийн хайрга агуулсан элсэнцэртэй 1,4 метрээс цайвар саарал өнгийн элсэнцэр чигжээстэй хайрга 4,0 метр хүртэл нэвтрээгүй үргэлжлэн тархсан байна.

/Фото. ПК1+500 Уулын бэл хормтой хэсэгт/

ПК1+900 орчимд үндсэн чулууны илэрцтэй толгодын харалдаа 50 метр орчим зайтай өнгөрнө.

ПК2+000-ПК4+000 хүртэл уулын бэл хормойгоор үргэлжлэн ПК5+500 -аас аажим өгсөнө.

ПК5+700 гадаргуудаа илэрцтэй, ПК5+800 ухаагаар давж цааш үргэлжлэн ПК5+900 д бэл хормойруу шилжинэ. ПК6+500 орчимд гуу жалга хөндлөн гарна.

ПК7+000 орчмоос бэл хормойн үргэжлэн , ПК8+060д намхан толгой, ПК8+720 эргэлт, энгэр бэлээр явж ПК8+800-ПК10+500 хооронд үндсэн чулууны илэрцүүдтэй.

ПК10+500 үндсэн чулууны илэрцтэй өгсүүр, ПК10+860 хадтай толгой 60 метрийн зайтай өнгөрнө.



/Фото. ПК8+720 Энэ хэсэгт өнгөн хөрсний дороос занарын өгөршлөөс үүссэн саарал өнгийн элсэнцэр чигжээстэй хайрга илэрсэн/

ПК11+300 эргэлт, бэл хормой , ПК11+280 дээр үндсэн чулууны илэрцтэй, ПК11+300-ПК12+000 илэрцтэй

ПК12+000 оос гуу жалга хөндлөн гарч , уул толгодын бэл хормой үргэлжлэн Баян-Овоо сум хүрнэ. ПК16+220 хадтай хамар, толгодын хажуугаар үндсэн чулуу илэрсэн. ПК18+200 илэрцүүдийн төгсгөл



/Фото. ПК16+200/

ПК18+880- дэрстэй уулын бэл хормойгоор уруудаж ПК20+840 дээр хөндийн рельеф зонхилно.

/Фото. ПК18+880 орчимд/

ПК20+720 аажим уруу хэсэг намхан толгодуудтай. ПК21+700-с хойшоо 60 метр орчимд 2 талдаа илэрцтэй хэсгээр явна. ПК20+840 өөс аажим уруудсаар ПК22+660 тэгш уужим хөндий руу орно. ПК22+460 элстэй хэсгээр гарна. ПК22+660 аас цааш хөндийгөөр явсаар ПК30+000 хүрч трасс төгсөнө.



/Фото. ПК30+020 орчимд трассын төгсгөл/

2.3. Геоморфологийн хэв шинж, физик-геологийн үзэгдэл үйл явц:

Судлагдсан раойн нь геоморфологийн ерөнхий тогтоцоороо Хангайн уулархаг системийн өмнөд төгсгөлд оршдог. Районы гадаргуугийн хэлбэржилт түүний ерөнхий зүй тогтлыг тодруулан рельефийн төрлүүдийг ялгасан байдаг.

Геоморфологийн шинж байдал гарал үүслийг үндэслэн рельефийн дараах төрлүүдийг ялгаж болно. Үүнд:

- Тектоник элэгдлийн рельеф:

Энэ хэв шинжийн рельефт уулс хоорондын хотгорт орших хэрчигдэл, идэгдэлд бага орсон, хавтгай, мөлгөр оройтой 2041-2203 метрийн харьцангуй өндөртэй уулс хамаарагдана. Рельеф үүсгэгч гол хүчин зүйл нь тектоник хөдөлгөөн, элэгдлийн үйл явц юм.

- Уулс хоорондын хуримтлалын тэгш рельеф:

Судлагдсан трассын зүүн болон хойгуур толгодорхог тэгш тал, хонхор хэлбэрийн 1652-1960 метрийн харьцангуй өндөртэй рельеф бүхий уулс хоорондын хотгор ажиглагдана. Толгодын хэлбэр нь тэгш хэмтэй, хоорондох хотгорууд нь хэмжээ ба гүний хувьд бага.

Судлагдсан авто зам нь Хангайн уулархаг мужийн баруун урд хэсэгт Баянхонгор уулын өвөрт баруун, зүүн хойт талаараа далайн түвшнээс 2390-2716 м өндөрт өргөгдсөн уулсаар хүрээлэгдсэн 4,0-5,0 км өргөнтэй хотгорыг дайран өнгөрнө. Уг хотгор нь урагшаа Харгантын гол тийш задгайрч голын хөндийд шилждэг. Рельефийн байдал, сумын төв оршиж байгаа талбайд аллювийн гаралтай хурдас тархсан зэргээс үзэхэд геологийн тухайн цаг үед энэ хэсэгт гүехэн устай нуурын горим ноёрхож байсан гэж дурьдсан байна.

2.4 Геологийн тогтоц:

Судлагдсан район нь Хангайн синклинорийн өмнөт хэсэгт Баянхонгорын хагарлын бүсийн Байдрагийн өргөгдөлд хамаарах бөгөөд энд хувирмал, бялхмал, тунамал гаралтай протерозой, палеозой, кайнозойн настай чулуулаг болон янз бүрийн насны гүний чулуулаг тархсан геологийн тогтоцын хувьд нийлмэл тогтоцтой юм.



Давхарга зүй.

Занарын давхаргадас PR2б

Дээд протерозойн хурдасны дотор занарын давхаргадас нь Уртын голын талбайд хамгийн их тархсан байдаг. Давхаргадасын дотоод бүтэц нийлмэл хүчтэй нугачигдсан шугаман чиглэлтэй адил хажуутай атираа ихэнх тохиолдолд хөнтрүү жигүүртэй атираанаас бүрдсэн синклиналь хэлбэрийн томоохон бүтцийг бүрдүүлнэ. Энэ давхаргадасыг олон төрлийн хувирмал занарууд бүрдүүлэх ба эдгээртэй салаавчлан хүчтэй хувиран занаржсан цахиурлаг элсэн чулуу, гравелитын үелэлүүд холилдон орсон байдаг. Уртын гол орчмын Байдрагийн голын хойд дэнжид энэ давхаргадасын дунд кварцын судлууд элбэг байх ба занар нь маш ихээр кварцжсан, мөн арсенопиритийн шигтгээ маш ихээр агуулсан байдаг. Цахиурлаг, шаварлаг занар нь бараан саарал, ногоон саарал өнгөтэй цулавтар заримдаа занарлаг бүтэцтэй, ховроор дун хагаралтай байна.

Шохойн чулуу, занарын давхаргадас PR2б

Шохойн чулуу занарын давхаргадасийн хурдас судалгааны талбайн Уртын гозгор уулын орчимд тархсан байдаг. Энэ давхаргадасын хурдас зүүн урагшаа сунасан маш тэнэгэр хөнтрүү байрлалтай бүсийг үүсгэсэн байдаг. Уг давхаргадасыг голлон саарал өнгийн шохойн чулуу мөн 1.0-10.0 м хүртэл зузаантай шаварлаг занарын нимгэн үелэлүүд салаавчлан оролцох байдлаар бүрдүүлнэ. Шохойн чулуу нь талстлаг ширхэгтэй, гантигжсан гранобласт структуртай, найрлаганд нь ганц нэг кварц, плагиоклазын болон кальцитын ширхэгүүд оролцсон байна.

Дунд-дээд чулуун нүүрсний галавын хурдас. С2-3

Энэ насны хурдас Уртын гол, Байдрагийн голын уулзвараас доош Байдрагийн голын хоёр хажууг дагаж сунасан дугуйвтар байдалтайгаар илэрнэ. Энэ хурдас эртний хурдсынхаа дээгүүр хучсан байдалтай байрлах ба дээд палеозойн боржин чулуулагт зүсэгдсэн байдалтай байх ба заримдаа эдгээрт \ксенолит\ үлдэц маягтай илэрнэ. Уг хурдас нь элсэн чулуу, занар, порфирит, ортофир заримдаа фельзит порфироос бүрдэнэ. Эдгээр нь протерозойн хурдасны дээр өнцөг болоод давхарга зүйн үл нийцлэгээр байрлан ул суурийн конгломератаар зааглагдан хучиж оршино. Ул суурийн конгломератын хайрга нь сайн мөлгөржсөн, цайвар саарал, цагаан өнгийн кварц, бага хэмжээгээр элсэн чулуу, занар, диоритоос бүрдэнэ. Эдгээрийг порфирит барьцалдуулга, конгломератын 50-60%-г хайрга эзлэх ба хайрганы 30 гаруй хувийг кварцууд эзэлнэ. Уртын голын урд хошуунд дараах зүсэлт ажиглагдана.

-Хүрэн, хүрэн цайвар өнгөтэй порфирит, цайвар ногоон занаржсан порфириттэй салаавчилсан хурдас.... 120м

-Цайвар, ногоон цайвар бялхмал чулуулгийн үелэл бүхий ягаан, улаавтар ягаан өнгийн төмрийн исэл бүхий бялхмал чулуулаг.. 200м

-Бараан саарал, саарал өнгийн порфирит.. 450м

Нийт зузаан 770м

Эдгээр чулуулаг дээд палеозойн гүний чулуулгийн дотор үлдэц байдлаар (ксенолит) нилээд тохиолдоно. Уг чулуулгийн насыг доод чулуун нүүрсний галавын хурдасны дээрээс ул суурийн конгломератаар зааглагдан оршдогийг гол үндэс болгон дунд-дээд чулуун нүүрсний галавын настай гэж үзжээ.

Кайнозойн бүлэг хурдсыг гуравдагч дөрөвдөгчийн 2 систем болгосон байдаг ба гуравдагчийн хурдсыг неоген, олигоцены настай 2 бүлэгт авч үздэг.

Неогены настай хүрмэн чулууны хучаас (N2-Q) нь Бүрэг хайрхан уулын оройд эртний тоналит, гнейс, дээд палеозойн боржинг хучсан байдаг. Хүрмэн чулуун хучаас нь өмнө зүгт 50-800 -ын хэвгий гадаргатай, урт нь 40-100 м, өргөн нь 10-100 м хүрдэг, 10-80 м зузаантай хааяа 10-12 метрийн ханан хад байдалтай илэрсэн байдаг. Хүрмэн чулууг дотор нь хлорит, цеолитын эрдсийн буйлсан (миндаль) шигтгээтэй, маш хатуу хар саарал өнгөтэй хүрмэн чулуу, нүх сүвэрхэг, галт уулын түлэгдсэн үнсэрхэг барзгар гадаргатай, порфир маягийн структуртэй оливинт базальт гэж ангилна.

Олигцены (Pg3) хурдас нь судлагдсан талбайд бага, ихэвчлэн Баян цагаан нуур, Өлзийт, Байдрагийн голын эх орчимд зураглалын явцад өрмөөр 25-50 метрийн гүнд өмнөх судлаачид илрүүлсэн. Мөн дээрх хотгоруудын зарим хэсэгт өгөршлийг заараг гадарга дээр 34м зузаантай плиоцены дарагдмал (погребенный) шаварлаг хурдас олж тогтоожээ. Олигоцений хурдас нь бор шаргал, улаан хүрэн өнгөтэй шавар, шавранцар зэргээс бүрдэнэ. Насыг В.И.Чулошников 1940 онд эрэл шалгаврын ажил хийх үедээ эртний гөрөөсний эвэр олж, плиоцены болохыг баталсан байна. Хүрмэн чулууны хучаасын насыг олигоцен - дөрөвдөгчийн түрүү үеийн настай гэж энэ насны хурдаснаас базальтын хэмхдэс олж давхарга зүйн харьцуулалтын аргаар тогтоосон байдаг.

Дөрөвдөгчийн хурдас нь судлагдсан талбайд маш өргөн тархалттай болно. Дөрөвдөгчийн хурдсыг дотор нь элэгдлийн хагшмал (аллюви), эртний бэлийн туугдас (пролюви), бэл хормойн хагшмал (делюви), байран (элюви) хурдас гэж ялгана. Үүнээс эртний туугдас, бэл хормойн хагшмал, байран хурдсууд нь хоорондоо нийлж, холилдсон хам гаралтай элювиально-делювиальны, эсвэл делювиально-пролювиальны хурдас хуримтлалын фацид хамрагдана. Элэгдэл зөөгдлийн хагшмал хурдас нь Өлзийт, Байдраг голын татам, гольдрол, татмын дэнжид ихэвчлэн тохиолдоно.

Судлагдсан трассын талбайн ихэнх газрыг эзэлсэн Байдраг, Өлзийт голын 1-р эрэмбийн дэнжүүд нь хуримтлалын хагшмал хурдсаас бүрдэнэ. Дөрөвдөгчийн хагшмал, туугдас, хормой бэлийн болон байран хурдас нь гол төлөв тоналит, габбро-диорит, боржин, кварцит, кварц, метагаббро, ховроор спиллит, диабаз, пироксенит болон цахиурлаг чулуулгийн хэмхдэс, элс, хайрга, дайрга сайн мөлгөржсөн бул чулуунаас бүрдэнэ.

Бүх сэвсгэр худсын 7-15% хааяа 30-40% нь кварцын мөхлөг, хэмхдэс, бул чулуу эзэлнэ. Харин голын татамд ихэвчлэн бор шаргал элс, шавар, хайрга, жижиг бул чулууны асгарга, овоолго, хошуурсан туугдас, далан байдлаар тохиолдоно.

Дээд палеозойн гүний чулуулгийн комплекс PZ3

Энэ комплексийн чулуулаг судалгааны талбайд Байдрагийн голын хоёр хажууг хамарч харьцангуй өргөн талбайд шток, дайк хэлбэртэйгээр Байдрагийн гүүрний орчим, мөн Байдраг-Өлзийт голын бэлчирт илэрнэ. Уг комплекс нь хойд талаараа доод протерозойн хувирмал чулуулагтай тектоникийн хагарлаар, өмнөд дунд хэсгээрээ дунд-доод чулуун нүүрсний галавын тунамал, бялхмал чулуулгийг зүсч хиллэдэг. Энэ хил заагийн гадаад контактын тунамал, бялхмал чулуулаг нь орговикжсон байх ба мөн дотоод контактад агуулагч чулуулгийн үлдэгдэл ксенолитууд ажиглагддаг. Уг комплексийг биотиттой боржин, биотит-эвэр хуурмагтай боржин, гранодиорит эдгээрийн дайкын чулуулгууд бүрдүүлнэ.

Энэ чулуулгууд том дунд ширхэгтэй байх ба заримдаа шигтгээт төрлүүдээс бүрдэх бөгөөд эдгээрт агуулагдах өнгөт эрдсүүдийн агуулга тэдгээрийн бөөгнөрөл харилцан адилгүй байдгаас боржингийн төрөл нь лейкократаас меленократын хооронд өргөн найрлагатай байдаг байна. Боржин нь ягаан, цайвар ягаан өнгөтэй байх ба эдгээр гүний чулуулагтай холбоотой илэрсэн дайкууд хүчиллэг, дунд найрлагатай байна. Баянхонгорын офиолитын бүс.

Баянхонгорын офиолитын бүс нь баруун хойш суналтай, 5-20 км өргөн, 200 гаруй км урт үргэлжилсэн гол төлөв серпентинит, офиолитын габбро, пироксенит зэрэг гипербазитын биетүүд, спилит-диабаз, порфир, базальтын зэрэгцээ судлууд, бөмбөлөг пиллоу лав эдгээрээс бүрдсэн суурилаг эффузив, венд-кембрийн настай шохойлог-терриген чулуулгаас бүрдэнэ.

Офиолит эвшлийн бүс нь зүйн хойд талаараа кембри-ордовикийн настай Загийн серийн ногоон занарын флишийн формацитай, баруун өмнөд талаараа архей-рифейн насиай хар занарын формацтай тус тус гүний хагарлаар хиллэдэг. Офиолит эвшлийн нас нь тогтоогдоогүй, харьцуулалтын аргаар венд-кембрийн настай гэж үздэг. (Зоненшайн 1997)

Хар занар нь Байдраг, Өлзийт голын бэлчирээс дээш Уртын голын адаг, Шовгорт голын бэлчир, Өлийн даваа, Хар сайр, Дааган дэлийн нурууны зүүн хойгуур Бүрдийн гол орчимд кварц, пиритээр баяжсан, алт агуулсан хар занарын томоохон бүс болж Баянхонгорын гол хагарал дагуу 5-15 км заримдаа түүнээс ч өргөн, 400 гаруй км баруун зүгт үргэлжилдэг.

Энэ бүсийг бүрдүүлэгч чулуулаг нь хүчтэй занаржсан шохойлог алевролит, шаварлаг филлит, жижиг ширхэгт полимикт элсэн чулуу, шаварлаг шохойн чулууны үелэл зэрэг терриген хурдас байгаад, өндөр эрэмбийн региональ метаморфизмийн процессоор хүчтэй хувирч нүүрслэг хар занар, шунгизит, метакварц болж хувирсан байна.

Хар занар бүсийн гол онцлог нь эрдэсжсэн гидротермаль уусмалаар эрчимтэй нэвчиж, уламжлагдан олон давтагдсан гүний томоохон хагарлуудаар шахагдан бутран үйрч, алт агуулсан кварц, пиритээр маш идэвхтэй баяжсан явдал юм. Энэ бүс дагуу алт агуулсан шаргалдуу цагаан өнгийн бүхэл бүтэн бүсүүд тохиолдоно. Хар занарт кварц, пиритийн агуулга 15-40%, заримдаа түүнээс ч их байдаг.

Хар занарын энэ бүс дагуу хүдэржилтийн шинж тэмдэг бусад хурдасаас илүү, гематит гётит зэрэг төмрийн усан исэл, пирит, халькопирит, пентлантит, алт зэрэг хүдрийн эрдэс, алт олборлосон эртний ухмал ул мөр маш элбэг ажиглагдана.

Тоналит гнейс нь Байдрагийн өргөгдлийн дагуу зүүн урдаас баруун хойд чиглэлд сунасан 20-50 км өргөн, 300 гаруй км үргэлжилсэн бүс үүсгэдэг.

Хамгийн эртний архей-рифейн настай саарал занарын энэ бүс нь хөх болон саарал өнгөтэй, дунд зэргийн жигд ширхэгтэй, плагиоборжин маягийн тоналит, хоёр гялтганууурт гнейс, хар саарал өнгөтэй, үелэг бүслүүрлэг хээ хэлбэрийн текстуртэй мигматит, цэхэр саарал өнгийн кварцит, улбардуу шаргал, хар саарал өнгийн гантиг, цахиуржсан шохойн чулуу, метагаббро, габбродиорит, амфболит, пироксенит зэрэг Байдрагийн комплексийн хувирмал чулуулгаас бүрдэнэ. Энэ хувирмал чулуулаг нь гүний хагарлаар тасарч бутарсан хэсэгтээ нэлээд эрчимтэй эрдэсжиж, брекчлэгдсэн нь ажиглагдана.

2.5 Геокриологийн нөхцөл

Эхний 30 км болох Баянхонгор аймгийн төвөөс Баян-Овоо сум хүртэлх трассын дагууд өрөмдсөн 2,5-4,2 метрийн гүнтэй 29 цооногт олон жилийн цэвдэг хөрс илрээгүй. */2025 оны 8-р сарын байдлаар/*

2.6 Гидрогеологийн нөхцөл:

Эхний 30 км болох Баянхонгор аймгийн төвөөс Баян-Овоо сум хүртэлх трассын дагууд өрөмдсөн 2,5-4,2 метрийн гүнтэй 29 цооногт хөрсний ус илрээгүй. */2025 оны 8-р сарын байдлаар/*

2.7 Цаг уур

Төлөвлөж байгаа авто замын зурвас талбайн цаг уурын үзүүлэлтүүдийг <<Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл>> АЗУАГН 2.01.01-2004 нормын үзүүлэлтүүдээр өглөө.

Төлөвлөж байгаа авто замын зурвас талбай говь цөлийн уур амьсгалын бүс рүү хошуурч тогтсон бөгөөд ихэнхдээ уулсын тахирлаж муруйсан хавчиг амаар өгсөх тул авто замын уур амьсгалын хээрийн бүс (II)–ийн уулсын завсар хоорондын дэд бүс (IIB) –д хамаарна.

Монгол орны авто замын уур амьсгалын бүсчлэлийн зураг дээр судалгааны зурвас талбайн байршлыг тоймлон үзүүлэв. *(Зураг №2)*

Уур амьсгалын бүсийн тодорхойлолтыг 1-дүгээр хүснэгтэнд, бусад үзүүлэлтүүдийг 2-15-дугаар хүснэгтүүдэд үзүүлэв.

Зураг №2

Монгол орны авто замын уур амьсгалын бүсчлэл



Монгол орны Авто замын уур амьсгалын бүсүүдийн инженер-геологийн нөхцөлийн тодорхойлолт

Хүснэгт II-1

Бүсийн дугаар, нэр	Дэд бүсийн индекс	Бүсийн товч тодорхойлолт	Цаг уурын болон инженер-геологийн зонхилох нөхцөл
1	2	3	4
II Авто замын уур амьсгалын хээрийн бүс	IIB. Уулын завсар хоорондын дэд бүс	Авто замын уур амьсгалын хуурай хүйтэй, сэрүүвтэр хахир, хуурайдуу сэрүүвтэр бэсрэг уулт хээр	Эргэн тойрны говь цөлөрхөг бүсийг бодвол харьцангуй цасархаг, бороорхог аянгалаг, салхитай хахир хүйтэн. Зөөгдөлийн шаварлаг үелэл ихтэй элсэрхэг шаварлаг хурдас тархсан.

Авто замын уур амьсгалын бүсүүдийн улирлын үргэлжлэх хугацаа*

Хүснэгт II-2

Бүс	Дэд бүс	Өвөл			хавар		зун		намар
		эхлэл	дуусах	үргэлжлэх хоног	дуусах	үргэлжлэх хоног	дуусах	үргэлжлэх хоног	үргэлжлэх хоног
II	IIB	1-9.XI 5..XI	15-24.III 19.III	126-143 134	6-12.V 9.V	45-52 48	8-19.IX 13.IX	112-156 129	44-54 49

Тайлбар :* Өвлийн дуусах хугацаа хаврын эхлэл, хаврынх зуны эхлэл, зуных намрын эхлэл, өвлийн эхлэл намрын дуусах хугацаа болно.

Хөрс, агаарын температур (^{0}C) үзүүлэлт

Хүснэгт II-3

Бүс	Дэд бүс	Хөрсний гадаргын температур, ^{0}C				Агаар орчны дундаж температур, ^{0}C		
		Олон жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн	О^{0}нэвчих гүн,см*	Олон жилийн дундаж	Хамгийн хүйтэн сарын	Хамгийн дулаан сарын
1	2	3	4	5	6	7	8	9
II	IIB	-0…+3	60-65	-41…-45	250-350	-2…+2	-20…-25	15…20

Тайлбар:* -О^{0}С нэвчих гүн ул хөрсний төрлөөс хамаарах тул дээд доод хязгаарыг авав.

Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа

Хүснэгт II-4

Бүс	Дэд бүс	Хөлдөлт			Гэсэлт		
		эхлэх	дуусах	хоног	эхлэх	дуусах	хоног
1	2	3	4	5	6	7	8
II	IIB	20-30.X 25.X	15.III-30.IV 5.IV	120-195 160	15.III-10.IV 25.III	15.IV-31.V 23.IV	20-50 35

Авто замын барилгын үйлдвэрлэлийн ажил явуулахад тохиромжтой болон тохиромжгүй улирлын үеүд

Хүснэгт II-5

Бүс	Дэд бүс	Дулааны улирал*			Хүйтний улирал
		эхлэх	дуусах	хоног	хоног
1	2	3	4	5	6
II	IIB	10.IV	19.X	192	173

Тайлбар:* -Авто замын үйлдвэрлэлийн хүйтэн улирлын эх нь дулаан улирлын төгсгөл, хүйтэн улирлын төгсгөл нь дулаан улирлын эх болдог.

Авто замын уур амьсгалын жилийн 4 улирлын салхины хурд, агаарын даралт, харьцангуй чийгшил

Хүснэгт II-6

Бүс	Дэд бүс	Салхины хурд, м/с				Даралт, мм Нд баганын өндрөөр	Харьцангуй чийгшил,%
		өвөл	Хавар	зун	Намар		
1	2	3	4	5	6	7	8
II	IIB	1.6-4	3-7	2-4	2.5-5.5	600-650	50-60

Авто замын уур амьсгалын бүсүүд дахь хур тундасны хэмжээ, мм

Хүснэгт II-7

Бүс	Дэд бүс	өвөл	Хавар	зун	намар	Жил	1 хоногт орох борооны хангамж,мм		Борооны хамгийн их орох эрчим мм/мин
							2%	1%	
1	2	3	4	5	6	7	8	9	10
II	IIB	3-10	15-30	150-200	20-35	220-250	80	104	1-1.50

Авто замын уур амьсгалын бүсийн нарны цацраг, нарны гийгүүллийн хэмжээ

Хүснэгт II-8

Бүс	Дэд бүс	Нарын цацраг, Мд/м^2			Нарны гийгүүлэл, цаг				
		нийлбэр	шууд	шингэсэн	Жил	XII	VI	XII сарын 1 өдөрт	VI сарын 1 өдөрт
1	2	3	4	5	6	7	8	9	10
II	IIB	4500-5300	2700-3200	3500-3700	2700-3300	150-200	270-300	6-7	9-10

Авто замын техник ашиглалтын түвшинд сөргөөр нөлөөлж болох уур амьсгалын үзэгдлүүд, тэдгээрийн үйлчлэл, мөчлөгийн хэмжээ

Хүснэгт II-9

Бүс	Дэд бүс	Техникийн уур амьсгалын хахир хатуу, балл		Уур амьсгалын хахиршил, балл	Нийт аянгын үйлчлэл		1 аянгын	
		Хүйтний	Дулааны		Өдрийн тоо	Үргэлжлэл, цаг	Үргэлжлэл минут	1 км^2 талбайн ниргэлтийн тоо
1	2	3	4	5	6	7	8	9
II	IIB	50-60	20-25	3-3,5	25-35	40-45	80-110	5-6

Хүснэгт II-9-ийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Нойтон цастай		Хялмаатай		Мөстлөгтэй		
		Өдрийн тоо	Үргэлжлэх цаг	Өдрийн тоо	Үргэлжлэх цаг	Өдрийн тоо	Зузаан, мм 10 жилд	Зузаан, мм 5 жилд
1	2	10	11	12	13	14	15	16
II	IIB	3-5	3-4	3-5	10-13	1-2	10	5

Хүснэгт II-9-ийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Ачаалал, кг/м^2		Металлын зэврэлт болох хугацаа, цаг	Тохиромжгүй өдрийн тоо					
		Салхины	Цасны		Халуун	Цасан шуурга-тай	Шороон шуурга-тай	Хүчтэй саохитай	Бороотой	Цастай
1	2	17	18	19	20	21	22	23	24	25
II	IIB	40-55	40-60	1500-2000	25-40	3-4	10-30	8-15	40-60	20-35

Хүснэгт II-9-ийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Халууны нөөц, нийлбэр ^{0}С		Хүйтний нөөц, нийлбэр ^{0}С			Хүйтний үргэлжлэх хугацаа, цаг		
		+20	+25	-20	-25	-30	-20^{0}С	-30^{0}С	-40^{0}С
1	2	26	27	28	29	30	31	32	33
II	IIB	800-2000	1000-1300	-300-2000	-900-1000	-1000-1500	1300-1600	200-400	200-400

Хүснэгт II-9-ийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Тогтвортой цасан бүрхүүл					
		Тогтох	Ханзрах	Хоног	Хамгийн зузааны дундаж, см	Нягт г/см^3	Нөөц ус, мм
1	2	34	35	36	37	38	39
II	IIB	20.XI-1.XII	10-20.III	60-120	10-15	0.20-0.25	10-20

Хүснэгт II-9-ийн үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Тогтвортой хүйтэн үед цочир дулааралттай, замд хальтиргаа гулгаатай байх хугацаа		Хүйтэн улирлын жавар хавсрагатай (>8м/с), хахир үе		Хөрсний 0-50 см гүний чийгшлийн нөөц, мм	
		Эхлэх	Дуусах	Өдрийн тоо	Цаг	Хавар	Намар
1	2	40	41	42	43	44	45
II	IIB	1.XII	15.III	100-125	500-650	10-30	30-50

Гол мөрний гадаргын усны горимын зарим үзүүлэлт

Хүснэгт II-10

Бүс	Дэд бүс	Гол мөрний гадаргын усны							
		Нягтшил	Жилийн дундаж урсац, л/сек	Дундаж урсацын давхраа, мм	Хаврын шар усны үерийн хамгийн их урсац, мм	Хамгийн их урсацын модуль, л/сек. ам.км	Мөсний хамгийн их зузааны дундаж, см	Мөс хадаалах хугацаа	Мөс задрах хугацаа
1	2	3	4	5	6	7	8	9	10
II	IIB	0,04-0,2	1-2	25-100	10-100	0,4-0,8	100-125	10-20.XI	21.V-с эрт

Хээр гадаа ажиллах авто замын ажилчдын хөдөлмөрийн био уур амьсгалын нөхцөл

Хүснэгт II-11

Бүс	Дэд бүс	Хүчил төрөгчийн нягт, г/см^3	Хувцас хунарын дулаан чанар, КЛО (хүндэвтэр ажлын нөхцөлөөр тооцов)			Уур амьсгал хүний биед, хоног		
			Өвлийн	Хавар, намрийн	Зуны	Таатай	Цочроох	Хурц
1	2	3	4	5	6	7	8	9
II	IIB	250-260	4,6-5,5	2,8-3,0	1,5-1,7	175-190	110-120	80-90

Авто замын үйлдвэрлэл, замчдын хөдөлмөрт уур амьсгалын нөлөөллийг үнэлэх итгэлцүүрүүд

Хүснэгт II-12

Бүс	Дэд бүс	Асфальто болон замын хучилт				
		Хүйтний	Хахирын	Халууны	Хур тунадасны	чийгшлийн
1	2	3	4	5	6	7
II	IIB	1,00	1,00	1,00	1,00	1,00

Хүснэгт II-12-ын үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Нөлөө үйлчлэлийн итгэлцүүр			
		Хүчтэй салхи шуурганы	Аянга цахилгааны	1 удаагийн их борооны	Цасны
1	2	3	4	5	6
II	IIB	1,00	1,00	1,00	1,00

Хүснэгт II-12-ын үргэлжлэл

Бүс	Дэд бүс	Нөлөө үйлчлэлийн итгэлцүүр						Уур амьсгалын үндсэн итгэлцүүр
		Хөдөлмөр хамгааллын хувцасны нөлөөлөл			Хүний биед уур амьсгалын нөлөөлөл			
		Өвөл	Хавар, намар	Зун	Таатай	Цочроох	Хурц	
1	2	7	8	9	10	11	12	13
II	IIB	1,00	1,00	1,00	1,00	1,00	1,00	1,00

Авто замын уур амьсгалын бүсүүдэд халуун
асфальт бетон хольц бэлтгэж дэвсэхэд тохиромжтой хугацаа

Хүснэгт II-13

Бүс	Дэд бүс	Асфальто болон замын хучилт		
		Эхлэх	Дуусгах	Хоног
1	2	3	4	5
II	IIB	18.IV-16.V (2.V)	15.III-19.IX (1.IX)	91-154 (122)

Авто замын уур амьсгалын бүсүүдэд хүйтэн, бүлээн
асфальт бетон хучилт хийхэд тохиромжтой хугацаа

Хүснэгт II-14

Бүс	Дэд бүс	Асфальто болон замын хучилт		
		Эхлэл	Дуусах	Хоног
1	2	3	4	5
II	IIB	3-30.III (16.III)	30.X-4.XII (15.XI)	220-278 (250)

Авто замын шороон далангийн чийг-дулааны горимын мөчлөгүүд

Хүснэгт II-15

Бүс	Дэд бүс	Замын даланд намар чийг хуримтлагдах			Даланд өвлийн чийг хуримтлагдах		Замын хөрс гэсэж чийг нэмэгдэх		Замын далан хуурайших
		Эхлэх	Дуусах	хоног	Дуусах	хоног	Дуусах	Хоног	Хоног
1	2	3	4	5	6	7	8	9	10
II	IIB	10.X	15. XI	36	1.IV	137	20.V	49	143

III. СУДАЛГААНЫ ТАЛБАЙН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН НӨХЦӨЛ, УЛ ХӨРСНИЙ ФИЗИК-МЕХАНИК ШИНЖ ЧАНАР

III.1 Талбайн инженер-геологийн нөхцөл

Төлөвлөж буй трассын талбай нь инженер-геологийн төвөгшлийн ангиллаар дунд зэргийн төвөгтэй нөхцөлтэй.

III.2 Ул хөрсний физик-механик шинж чанар

Төлөвлөж байгаа трассын дагуух талбайн өнгөн хөрсний дороос тархсан ул хөрсүүдийг инженер-геологийн 8 элемент (ИГЭ)-д ангилан тус бүрийн физик-механик шинж чанарын үзүүлэлтүүдийг өглөө. Ул хөрсний тархалт, зузаалгийг инженер-геологийн зүсэлт зургаар үзүүлэв. */Хавсралт зураг №б-25/*

<u>Өнгөн хөрс.</u> Ургамлын үндэс бүхий өнгөн хөрс нь судлагдсан трассын дагууд 0,1-0,3 метрийн зузаантайгаар тархсан байна.

<u>ИГЭ-1. Жижиг ширхэгтэй элсэн ул хөрс.</u>

Орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, цайвар шаргал өнгийн бага чийгтэй, жижиг ширхэгтэй элсэн ул хөрс. */Инженер-геологийн зүсэлт үз/.*

Жижиг ширхэгтэй элсэн ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга 14,6
- янз бүрийн ширхэгтэй элс 81,0

- тоос 2,7
- шаварлаг хэсэг 1,7 тус тус агуулагдана.

Жижиг ширхэгтэй элсэн ул хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-1-д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-1

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
1	Байгалийн чийг	*нэгжийн хувь*	0.020
2	Хатуу хэсгийн нягт	*г/см^3*	2.67
3	Хөрсний нягт	*г/см^3*	2,02
4	Эрдэслэг хэсгийн нягт	*г/см^3*	1,98
5	Сүвшил	*хувь*	25,83
6	Сүвшлийн коэффициент	*нэгжийн хувь*	0.348
7	Чийглэгийн зэрэг	*нэгжийн хувь*	0,15

Жижиг ширхэгтэй элсэн ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНбД50-103-21 нормын 4,1-р хүснэгтээр тооцож хүснэгт III-2–д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-2

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C^H	C^I	C^{II}	φ^H	φ^I	φ^{II}	E^H
6	4	6	38	34,2	38	48

Жижиг ширхэгтэй элсэн ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – I.

<u>ИГЭ-2. Хайргархаг элсэн ул хөрс.</u>

Орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, бор саарал өнгийн бага чийгтэй, хайргархаг элсэн ул хөрс. */Инженер-геологийн зүсэлт үз/.*

Хайргархаг элсэн ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга 31,7
- янз бүрийн ширхэгтэй элс 64,1
- тоос 2.5
- шаварлаг хэсэг 1,7 тус тус агуулагдана.

Хайргархаг элсэн ул хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-3-д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-3

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
1	Байгалийн чийг	*нэгжийн хувь*	0.031
2	Хатуу хэсгийн нягт	*г/см^3*	2.66
3	Хөрсний нягт	*г/см^3*	2,10
4	Эрдэслэг хэсгийн нягт	*г/см^3*	2,04
5	Сүвшил	*хувь*	23,38
6	Сүвшлийн коэффициент	*нэгжийн хувь*	0.307
7	Чийглэгийн зэрэг	*нэгжийн хувь*	0.25

Хайргархаг элсэн ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНбД50-103-21 нормын 4,1-р хүснэгтээр тооцож хүснэгт III-4–д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-4

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C^{H}	C^{I}	C^{II}	φ^{H}	φ^{I}	φ^{II}	E^{H}
2	1,3	2	43	38,7	43	50

Хайргархаг элсэн ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – III.

<u>ИГЭ-3. Элсээр чигжигдсэн хайрган ул хөрс.</u>

Орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, цайвар саарал өнгийн бага чийгтэй, элсээр чигжигдсэн хайрган ул хөрс. */Инженер-геологийн зүсэлт үз/.*

Элсээр чигжигдсэн хайрган ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга 57,1
- янз бүрийн ширхэгтэй элс 39,2
- тоос 2,2
- шаварлаг хэсэг 1.5 тус тус агуулагдана.

Элсээр чигжигдсэн хайрган ул хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-5-д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-5

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
1	Байгалийн чийг	*нэгжийн хувь*	0.019
2	Хатуу хэсгийн нягт	*г/см^3*	2.66
3	Хөрсний нягт	*г/см^3*	2,22
4	Эрдэслэг хэсгийн нягт	*г/см^3*	2,18
5	Сүвшил	*хувь*	17,92
6	Сүвшлийн коэффициент	*нэгжийн хувь*	0.218
7	Чийглэгийн зэрэг	*нэгжийн хувь*	0.23

Элсээр чигжигдсэн хайрган ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНбД50-103-21 нормын 4,1-р хүснэгтээр тооцож хүснэгт III-6–д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-6

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C^{H}	C^{I}	C^{II}	φ^{H}	φ^{I}	φ^{II}	E^{H}
2	1,3	2	43	38,7	43	50

Элсээр чигжигдсэн хайрган ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – IV.

ИГЭ-4. Хайрга агуулсан элсэнцэр ул хөрс.

Орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, бор өнгийн хатуу урсамтгайн үзүүлэлттэй, хайрга агуулсан элсэнцэр ул хөрс. */Инженер-геологийн зүсэлт үз/.*

Хайрга агуулсан элсэнцэр ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга 17,2
- янз бүрийн ширхэгтэй элс 60,1
- тоос 15,5
- шаварлаг хэсэг 7,2 тус тус агуулагдана.

Хайрга агуулсан элсэнцэр ул хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-7-д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-7

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
1	Байгалийн чийг	*нэгжийн хувь*	0.049
2	Урсалтын хязгаар дахь чийг	*нэгжийн хувь*	0.180
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг	*нэгжийн хувь*	0.134
4	Уян налархайн тоо	*нэгжийн хувь*	0.046
5	Хатуу хэсгийн нягт	*г/см^3*	2.68
6	Хөрсний нягт	*г/см^3*	1,99
7	Эрдэслэг хэсгийн нягт	*г/см^3*	1,89
8	Сүвшил	*хувь*	29,30
9	Сүвшлийн коэффициент	*нэгжийн хувь*	0.417
10	Чийглэгийн зэрэг	*нэгжийн хувь*	0.32
11	Урсамтгайн үзүүлэлт		<0

Хайрга агуулсан элсэнцэр ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНбД50-103-21 нормын 4,4-р хүснэгт болон 4,5-р хүснэгтээр тооцож хүснэгт III-8–д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-8

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C^H	C^I	C^{II}	φ^H	φ^I	φ^{II}	E^H
21	14	21	30	26	30	32

Хайрга агуулсан элсэнцэр ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – II.

ИГЭ-5. Элсэнцэрээр чигжигдсэн хайрган ул хөрс. /Өгөршил/

Орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, цайвар шаргал өнгийн хатуу урсамтгайн үзүүлэлттэй, үндсэн чулууны өгөршлөөс үүссэн элсэнцэрээр чигжигдсэн хайрган ул хөрс. */Инженер-геологийн зүсэлт үз/.*

Элсэнцэрээр чигжигдсэн хайрган ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга 55,8
- янз бүрийн ширхэгтэй элс 25,5
- тоос 11,4

- шаварлаг хэсэг 7,8 тус тус агуулагдана.

Элсэнцэрээр чигжигдсэн хайрган ул хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-9-д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-9

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
1	Байгалийн чийг	*нэгжийн хувь*	0.052
2	Урсалтын хязгаар дахь чийг	*нэгжийн хувь*	0.195
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг	*нэгжийн хувь*	0.140
4	Уян налархайн тоо	*нэгжийн хувь*	0.055
5	Хатуу хэсгийн нягт	*г/см^3*	2.69
6	Хөрсний нягт	*г/см^3*	2,20
7	Эрдэслэг хэсгийн нягт	*г/см^3*	2,09
8	Сүвшил	*хувь*	22,12
9	Сүвшлийн коэффициент	*нэгжийн хувь*	0.284
10	Чийглэгийн зэрэг	*нэгжийн хувь*	0.49
11	Урсамтгайн үзүүлэлт		<0

Элсэнцэрээр чигжигдсэн хайрган ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНбД50-103-21 нормын 4,7 болон 4,9-р хүснэгтээр тооцож хүснэгт III -10–д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-10

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C^H	C^I	C^{II}	φ^H	φ^I	φ^{II}	E^H
11	7,3	11	34	29,5	34	35

Элсэнцэрээр чигжигдсэн хайрган ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – IV.

<u>ИГЭ-6. Хайрга агуулсан шавранцар ул хөрс.</u>

Орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, бор өнгийн хатуу урсамтгайн үзүүлэлттэй, хайрга агуулсан шавранцар ул хөрс. */Инженер-геологийн зүсэлт үз/.*

Хайрга агуулсан шавранцар ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга 13,9
- янз бүрийн ширхэгтэй элс 49,1
- тоос 21,8
- шаварлаг хэсэг 15,2 тус тус агуулагдана.

Хайрга агуулсан шавранцар ул хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-11-д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-11

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
1	Байгалийн чийг	*нэгжийн хувь*	0.096
2	Урсалтын хязгаар дахь чийг	*нэгжийн хувь*	0.250
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг	*нэгжийн хувь*	0.155

4	Уян налархайн тоо	*нэгжийн хувь*	0.095
5	Хатуу хэсгийн нягт	*г/см³*	2.72
6	Хөрсний нягт	*г/см³*	1,97
7	Эрдэслэг хэсгийн нягт	*г/см³*	1,79
8	Сүвшил	*хувь*	34,00
9	Сүвшлийн коэффициент	*нэгжийн хувь*	0.521
10	Чийглэгийн зэрэг	*нэгжийн хувь*	0.51
11	Урсамтгайн үзүүлэлт		<0

Хайрга агуулсан шавранцар ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНбД50-103-21 нормын 4,4-р хүснэгт болон 4,5-р хүснэгтээр тооцож хүснэгт III-12–д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-12

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C^{H}	C^{I}	C^{II}	φ^{H}	φ^{I}	φ^{II}	E^{H}
37	24,6	37	25	21,7	25	27

Хайрга агуулсан шавранцар ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – II.

<u>ИГЭ-7. Шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрс.</u>

Орчин үеийн дунд дөрөвдөгчийн настай, делюви-пролювийн гаралтай, цайвар бор өнгийн хатуу урсамтгайн үзүүлэлттэй, элсэнцэрээр чигжигдсэн хайрган ул хөрс. */Инженер-геологийн зүсэлт үз/.*

Шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрсний ширхгийн бүрэлдэхүүнд (%):

- хайрга 50,6
- янз бүрийн ширхэгтэй элс 23,7
- тоос 12,1
- шаварлаг хэсэг 13,6 тус тус агуулагдана.

Шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрсний физик үзүүлэлтүүдийг хүснэгт III-13-д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-13

Д/д	Физик шинж чанарын үзүүлэлтүүд	Нэгжийн хувь	Дундаж утга
1	Байгалийн чийг	*нэгжийн хувь*	0.074
2	Урсалтын хязгаар дахь чийг	*нэгжийн хувь*	0.243
3	Имрэгдлийн хязгаар дахь чийг	*нэгжийн хувь*	0.154
4	Уян налархайн тоо	*нэгжийн хувь*	0.089
5	Хатуу хэсгийн нягт	*г/см³*	2.71
6	Хөрсний нягт	*г/см³*	2,19
7	Эрдэслэг хэсгийн нягт	*г/см³*	2,04
8	Сүвшил	*хувь*	24,91
9	Сүвшлийн коэффициент	*нэгжийн хувь*	0.332
10	Чийглэгийн зэрэг	*нэгжийн хувь*	0.60
11	Урсамтгайн үзүүлэлт		<0

Шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрсний механик шинж чанарын үзүүлэлтүүдийн норматив болон тооцооны утгыг БНбД50-103-21 нормын 4,6 болон 4,8-р хүснэгтээр тооцож хүснэгт III -14–д нэгтгэн үзүүлбэл:

Хүснэгт III-14

Барьцалдах хүч, кПа			Дотоод үрэлтийн өнцөг, градус			Хэв гажилтын модуль, МПа
норматив утга	тооцооны утга		норматив утга	тооцооны утга		норматив утга
C^{H}	C^{I}	C^{II}	φ^{H}	φ^{I}	φ^{II}	E^{H}
27	18	27	39	33,9	39	36

Шавранцараар чигжигдсэн хайрган ул хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад – IV.

ИГЭ-8. Цахиурлаг занар

Хөх саарал өнгөтэй, газрын гадаргуу хэсэгт ил гарсан хэсгээрээ өгөршилд их орж ан цавшсан, доод-дунд карбоны настай занар. /*Инженер-геологийн зүсэлт үз./* Занарын өгөршлийн зэрэг Квс=0.80 байгаа нь сулавтар өгөршсөн хөрсөнд нормчлогдоно. Дээжүүдэд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнгээс үзвэл эзэлхүүн жин нь 2,38 г/см^3 байна. Газар шорооны ажлын зэрэг нь - VII.

Занар чулууны лабораторийн үзүүлэлтүүд

Хүснэгт III-15

